

1-р шат



Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ) нь Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүүхдийн Сантай хамтран MICS Plus (ОУБТС+) судалгааг 2020 оны 9 сараас хэрэгжүүлж эхэлсэн. MICS Plus нь COVID-19 цар тахлын үед хүүхэд, гэр бүл, өрхийн нөхцөл байдлыг тодорхойлох өгөгдлийг бий болгож, шийдвэр гаргагчид болон оролцогч талуудад мэдээлнэ. Энэхүү хормын хувилбарт 2020 оны 9 сарын 18-аас 10 сарын 25-ны хооронд дуудлага хийгдсэн 1-р шатны үр дүнг нэгтгэн харуулав.



Арга зүй, аргачлал

MICS Plus аргачлал нь түүврийн төлөөлөх чадвартай, өрхөд суурилсан статистик судалгааны давуу талыг компьютерийн тусламжтай утсаар ярилцлага (CATI) авах технологийн бодит цаг үеийн мэдээллийг үргэлжилсэн хугацаанд мэдээлэх давуу талтай хослуулсан. Мэдээлэл цуглуулах горим нь судлаач уламжлалт аргаар нүүр тулж ярилцах бус, харин хариулагчтай* шууд утсаар холбогдож мэдээлэл цуглуулах явдал юм.

ОУБТС+ судалгааны аргачлалыг дараах зүйлд үндэслэсэн:

- Өрх/өрхийн гишүүдийн утасны дугаарыг багтаасан өрхийн түүврийн хүрээнээс магадлалт түүврээр өрхийг сонгох
- Сонгогдсон өрх рүү урт хугацаанд шууд дуудлага хийж ярилцлага авах


Судалгааны түүврийг ҮСХ-ны Хүн амын өрхийн мэдээллийн сан (ХАӨМС)-аас авсан. 2020 оны 1-р сарын байдлаар бүртгэлд суурилсан Хүн ам, орон сууцны тооллогыг түүврийн хүрээ болгон ашигласан. Нийт түүврийн зорилтот хэмжээ 2200 өрх.

Хамрагдалтын түвшинг нэмэгдүүлэх зорилгоор ХАӨМС-ын утасны дугаарыг баталгаажуулах, утасны дугаар байхгүй өрхүүдтэй орон нутгийн хэлтсээр дамжүүлэн холбогдож, хамгийн сүүлийн утасны дугаарыг олж авсан. ОУБТС+ эхний шатны судалгаанд хамрагдаагүй өрхүүдийг орлуулахын тулд загварт суурилсан орлуулах аргыг ашигласан.

ОУБТС+ нь үндэсний хэмжээний төлөөлөх чадвар бүхий судалгаа юм. Хот, хөдөө нь түүврийн гол домайн бөгөөд түүврийг дараах байдлаар хуваарилсан. 4 бүс тус бүрээс 400 өрх, Улаанбаатар хотоос 600 өрх сонгосон. Судалгааны дараагийн шатны мэдээлэл цуглуулалтыг өмнөх шатанд хамрагдсан ижил өрхийг хамруулж, панел дата үүсгэнэ. Судалгааны эхний шатанд 2020 оны 9 сарын 18-аас 10 сарын 25-ны хооронд өрхүүд цар тахалын үеэр COVID-19-өөс өөрийгөө хамгаалах дадал, мэдээллийн эх үүсвэр, засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээнд хамрагдсан байдлын талаар тодруулсан. 2-17 насны хүүхэд, өрхийн зайн сургалтын талаарх туршлага нь эхний шатны гол сэдэв байв.

* Өрх бүрт дуудлага хийж судалгааг авахдаа “өрхийн талаар мэдлэгтэй, насанд хүрсэн өрхийн гишүүн”-тэй ярилцсан. Судалгаанд оролцогчдыг санамсаргүй байдлаар сонгоогүй тул, хариулагчийн өөрийн шинж чанар, үзэл бодол, зан үйлийн хэв маягт үндэслэсэн өгөгдөл нь Монгол улсын насанд хүрсэн нийт хүн амын төлөөлөл болж чадахгүй.

Түүврийн хэмжээ, бүсээр







Түүврийн шинж байдал

Хүн амын нас, хүйсийн суврага

Өрхийн бүтэц, өрхийн тэргүүний шинж байдал




Хүн амын нас, хүйсийн суврагаас харахад ОУБТС+ судалгааны түүвэрт хамрагдсан хүн ам нь 2020 оны бүртгэлд суурилсан Хүн ам, орон сууцны тооллогтой ижил бүтэцтэй байна. Арван өрх тутмын хоёр нь эмэгтэй тэргүүнтэй буюу өрх толгойлсон эмэгтэйчүүд байна. Нийт өрхийн гуравны нэг (32 хувь) нь 18-аас доош насны хүүхэдгүй, 65 хувь нь 2-17 насны дор хаяж нэг хүүхэдтэй өрхүүд байна.



Өрхийн шинж байдал


Сууцны төрөл

Өрхийн эзлэх хувь, сууцны төрөл, хот хөдөөгөөр



Өрхийн интернэт ашиглалт

Өрхийн эзлэх хувь, интернет холболт, хот хөдөөгөөр



Хотын өрхүүдийн 40 орчим хувь нь орон сууцанд амьдардаг бол хөдөөгийн өрхүүдийн 60 хувь нь гэрт амьдарч байна. Нийт өрхийн 73 хувь нь интернэттэй бөгөөд хот, хөдөөгөөр ихээхэн ялгаатай байна. Хөдөөгийн 10 өрх тутмын 4 нь интернэт холболтгүй бол хотын 10 өрх тутмын 2 нь интернэт холболтгүй байна. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2018 (НУТС 2018)-аар нийт өрхийн ердөө 36 хувь нь интернэтэд холбогдсон байсан нь сүүлийн 2 жилд өрхүүдийн интернэт холболтод ихээхэн нэмэгдсэн байгааг илтгэж байна.




КОВИД-19-ийн нөлөө

КОВИД-19 халдвараас өөрийгөө хамгаалж буй арга хэрэгсэл

Хот, хөдөөгөөр


Хариулагчийн эзлэх хувь, өөрийгөө КОВИД-19 халдвараас хамгаалахын тулд хийж буй арга хэмжээгээр



Судалгаанд оролцогчдоос КОВИД-19 халдвараас өөрийгөө хамгаалахын тулд ямар арга хэмжээ авч буйг тодруулахад амны хаалт хэрэглэх (79 хувь), гараа угаах (74 хувь) арга хэмжээг түгээмэл авч байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын гуравны нэг нь өдөр бүр чийгтэй цэвэрлэгээ хийдэг, 20 хувь нь дархлаагаа дэмжиж байгаа гэж хариулжээ. Эдгээр КОВИД-19 халдвараас өөрийгөө хамгаалах арга хэмжээнүүдийг хот, хөдөөгөөр харвал хотод илүү хэрэгжүүлж байна. Олон хүн цугласан газраар явахгүй байх гэдэг арга хэмжээг судалгаанд оролцогчдын 11 хувь нь хэрэгжүүлж байна. Энэ удаагийн судалгааны мэдээлэл цуглуулалтыг бүх нийтийн хөл хорио тогтоохоос өмнө цуглуулсан гэдгийг энд тэмдэглэх хэрэгтэй юм. Дээрх арга хэмжээнүүдийг хүйсээр харвал эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү гараа угаах, өдөр бүр чийгтэй цэвэрлэгээ хийж, дархлаагаа дэмждэг нь ажиглагдаж байна.


Хариулагчийн хүйсээр

Хариулагчийн эзлэх хувь, өөрийгөө КОВИД-19 халдвараас хамгаалахын тулд хийж буй арга хэмжээгээр



КОВИД-19-ийн талаар мэдээлэл авдаг эх сурвалж

Хариулагчийн эзлэх хувь, КОВИД-19-ийн талаар мэдээлэл авдаг эх сурвалжаар




КОВИД-19-ийн талаар мэдээллийн гол эх үүсвэрийн хувьд 10 хүн тутмын 9 нь Телевизээс мэдээлэл авдаг бол, 10 хүн тутмын 3 нь нийгмийн сүлжээ болон гар утасны мессежээр мэдээлэл авсан байна. Засгийн газар КОВИД-19 цар тахалын үед иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг авсан. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ нийт өрхийн 68 хувьд хүрсэн байна. Хүүхэдтэй өрхийн хувьд энэ үзүүлэлт 98 хувь байна. Нийгмийн даатгалын төлбөрийг чөлөөлөх арга хэмжээ хотод илүү хэрэгжсэн (хөдөөд 21 хувь, хотод 32 хувь) бол ноолуурын урамшуулал хөтөлбөр хөдөөд 59 хувь, хотод 4 хувь хамрагдсан байна. Засгийн газраас үзүүлж буй дэмжлэгийг өрхийн тэргүүний хүйсээр мэдэгдэхүйц ялгаатай байна.


КОВИД-19 цар тахалын үед Засгийн газрын хэрэгжүүлсэн арга хэмжээ

КОВИД-19 цар тахалын үед эдийн засгийг эрчимжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд хамрагдсан өрхийн хувь

Хот, хөдөөгөөр



Өрхийн тэргүүний хүйсээр






Хүүхдийн зайн сургалт

Сургуульд хамрагдалт

COVID-19-ийн улмаас 2020 оны 2 сард сургууль/цэцэрлэгийн танхимын үйл ажиллагааг хаахаас өмнө цэцэрлэгт явж/сургуульд сурч байсан 2-17 насны хүүхдийн эзлэх хувь




2-17 насны хүүхдүүдийн 86 хувь нь КОВИД-19 цар тахалын улмаас 2020 оны 2 сард сургууль/цэцэрлэгийн үйл ажиллагааг хаахаас өмнө сургууль/цэцэрлэгт хамрагдаж байсан байна. Хот, хөдөөгийн хооронд ялгаа бага байна. 2-5 насны хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдалт хамгийн бага байна.



Аливааг танин мэдэхэд нь гэр бүлийн гишүүдийн дэмжлэг үзүүлдэг хүүхэд

Аливааг танин мэдэхэд нь гэр бүлийн гишүүдийн дэмжлэг үзүүлдэг хүүхэд

Сүүлийн 3 оногт аливааг сурах, танин мэдэх болон сургуульд бэлтгэхэд нь өрхийн насанд хүрсэн хэн нэг гишүүн цаг гаргасан 2-4 настай хүүхдийн хувь




Судалгааны үр дүнг НҮТС 2018-ын үр дүнтэй харьцуулахад аливааг танин мэдэхэд нь гэр бүлийн гишүүдийн дэмжлэг үзүүлдэг хүүхдийн хувь мэдэгдэхүйц өөрчлөлт ажиглагдахгүй байна. Сүүлийн 3 өдрийн хугацаанд насанд хүрэгчид 2-4 насны хүүхэдтэй хамт сурч, дэмжих үйл ажиллагаа хүүхдийн хүйсээр мэдэгдэхүйц ялгаатай байгааг ажиглаж болно. НҮТС 2018-аар хөвгүүд, охидыг дэмжиж буй хувь харгалзан 57 хувь, 59 хувь байсан бол энэ судалгаагаар 72 хувь, 49 хувь болж өөрчлөгджээ.

Тэмдэглэл: Ном уншиж өгөх, үлгэр, түүх, домог ярьж өгөх, хамт дуу дуулах, гадаа авч гаран хамтдаа зугаалах, хамт тоглох, хамтлаа эд юмсыг нэрлэж, тоо

Зайн сургалтын үндсэн хэлбэрүүд нь ТВ хичээл болон онлайн хичээлүүд байсан. Нэмж дурдахад багш болон сургууль нь бусад харилцаа холбооны хэлбэрүүд, тухайлбал утас, имэйл, нийгмийн сүлжээ гэх мэтийг ашиглан хүүхдүүдтэй холбоо барьж байж магадгүй юм

ТВ/радио хичээл үзэж/сонссон хүүхэд

ТВ/радио хичээл үзэж/сонссон 2-17 насны хүүхдийн эзлэх хувь, ТВ/радио хичээл үзэж/сонссон 2-17 насны хүүхдийн ажлын өдөрт дунджаар телевизийн хичээлд зарцуулсан хугацаа, минутаар




() 25-49 жинлээгүй ажиглалтад суурилсан тооцоолол

Хөдөөгийн 10 хүүхэд тутмын 4 нь ТВ/Радио хичээлд хамрагдаагүй байна. Хотын хүүхдүүдийн хувьд бага зэрэг дээр байна. Гэсэн хэдий ч хотын 3 хүүхэд бүр ТВ/Радио хичээлд хамрагдаж чадаагүй байгаа нь боловсролын үйлчилгээний тасралтгүй байдалд бэрхшээл үүсгэж болзошгүй юм.

ТВ/радио хичээл үзэж/сонссон төхөөрөмж

ТВ/радио хичээл үзэж/сонссохын тулд төхөөрөмж ашигласан 2-17 насны хүүхдийн эзлэх хувь




Бараг бүх хүүхэд ТВ/радио хичээл үзэхдээ телевиз ашигласан байна. Хүүхдүүдийн дөнгөж 4 хувь нь зөөврийн болон суурин компьютерийг зайн сургалтанд ашигладаг гэж хариулсан байна.



Нэмэлт онлайн хичээл

Сургууль/багшаас нэмэлт онлайн хичээлд хамрагдах боломж

КОВИД-19-ийн улмаас 2020 оны 2 сард сургууль/цэцэрлэгийн танхимын үйл ажиллагааг хаахаас өмнө цэцэрлэгт явж/сургуульд сурч байсан, сургууль, багшаасаа нэмэлт онлайн хичээл авсан 6-17 насны хүүхдийн эзлэх хувь, ажлын өдөрт нэмэлт хичээл хийхэд зарцуулсан дундаж хугацаа, минутаар



() 25-49 жинлээгүй ажиглалтад суурилсан тооцоолол


Хотын хүүхдүүдийн тэн хагас нь, хөдөөгийн хүүхдүүдийн хувьд арай илүү хувь (56 хувь) нь сургууль, багш нараасаа нэмэлт хичээл авсан байна. Тэд өдөрт дунджаар нэмэлт онлайн хичээлд 68-79 минут зарцуулж байна. Хувийн сургуулийг улсын сургуультай харьцуулахад нэмэлт хичээл өгөх нь илүү байгаа бөгөөд нэмэлт хичээлд зарцуулж буй хугацаа 40 минутаар илүү байна. Нэмэлт хичээл гэдэг нь Засгийн газраас хэрэгжүүлсэн ТВ/Радио хичээлээс гадна сургууль эсвэл багшаас өгсөн хичээлийг хэлнэ.



Гэрийн даалгавар


Гэрийн даалгавартай байсан хүүхэд

КОВИД-19-ийн улмаас 2020 оны 2 сард сургууль/цэцэрлэгийн танхимын үйл ажиллагаа хаахаас өмнө цэцэрлэгт явж/сургуульд сурч байсан, гэрийн даалгавартай байсан 6-17 насны хүүхдийн эзлэх хувь



Гэрийн даалгавар хийхдээ дэмжлэг авдаг хүүхэд

КОВИД-19-ийн улмаас 2020 оны 2 сард сургууль/цэцэрлэгийн танхимын үйл ажиллагаа хаахаас өмнө цэцэрлэгт явж/сургуульд сурч байсан бөгөөд гэрийн даалгавартай байсан, гэрийн даалгавар хийхдээ хэн нэгнээс тусламж авсан 6-17 насны хүүхдийн хувь, гэрийн даалгавар хийхэд тусласан хүнээр



Гэрийн даалгаварт зарцуулсан хугацаа

Гэрийн даалгавартай байсан 6-17 насны сургуульд сурдаг хүүхдийн гэрийн даалгаварт зарцуулсан дундаж хугацаа, минутаар




() 25-49 жинлээгүй ажиглалтад суурилсан тооцоолол

КОВИД-19-ын улмаас 2020 оны 2 сард сургууль/цэцэрлэгийн танхимын үйл ажиллагаа хаагдахаас өмнө сургууль/цэцэрлэгт хамрагдаж байсан 4 хүүхэд тутмын 3 нь гэрийн даалгавартай байсан бөгөөд хот хөдөөгөөр ялгаа бага байна. Гэрийн даалгавартай байсан 2 хүүхэд тутмын нэг нь эцэг эхээсээ, 4 хүүхэд тутмын 1 нь ах, эгчээсээ дэмжлэг авсан байна. Гэрийн даалгавартай байсан 4 хүүхэд тутмын нэг гэрийн даалгавраа хийхэд ямар нэг дэмжлэг аваагүй байна.

Сургууль, багштай холбоо барьсан байдал


КОВИД-19-ийн улмаас 2020 оны 2 сард сургууль/цэцэрлэгийн танхимын үйл ажиллагаа хаахаас өмнө цэцэрлэгт явж, сургуульд сурч байсан, гэрийн даалгавар эсвэл нэмэлт хичээлийн талаар багштай холбоо барьсан болон зайн сургалтын талаар сургуулиас холбоо барьсан 6-17 насны хүүхдийн эзлэх хувь



Дөрвөн хүүхэд тутмын нэг нь гэрийн даалгавар, нэмэлт хичээлийн талаар багш, сургуультай холбоо бариагүй байна. Хөдөөгийн хүүхдүүдийн гэр бүлийн гишүүд багш нараас арай илүү холбоо барьдаг байна. Багш болон сургуулиас тухайн хүүхдийн талаар өрхтэй холбоо барих нь арай бага байна. Хотын 4 хүүхэд тутмын 1, хөдөөгийн 3 хүүхэд тутмын 1 хүүхдийн багш, сургуулиас өрхтэй огт холбоо бариагүй байна.

Сургалтын материал авсан байдал


КОВИД-19-ийн улмаас 2020 оны 2 сард сургууль/цэцэрлэгийн танхимын үйл ажиллагаа хаахаас өмнө цэцэрлэгт явж, сургуульд сурч байсан, сургалтын материал, видео хичээл, бие даан сурах CD авсан 2-17 насны хүүхдийн эзлэх хувь



Зайн сургалтын явцад сургалтын материалын хүртээмж хангалтгүй бөгөөд хүүхдүүдийн тал хувьд ч хүрэхгүй байна. Хөдөөгийн хүүхдүүдийн 29 хувь, хотын хүүхдүүдийн 44 хувь нь сургууль, багш нараасаа сургалтын материал авчээ. Цаашилбал, хүүхдүүдийн сурлагын амжилтын талаар мэдээлэл хязгаарлагдмал байна. 2019-20 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 3-12 дугаар ангийн хөдөөгийн хүүхдүүдийн талаас илүү хувь, хотын хүүхдүүдийн 42 хувийн сурлагын оноог нь хариулагч мэдэхгүй байна.

Хүүхдийн сурлагын амжилт

КОВИД-19-ийн улмаас 2020 оны 2 сард сургууль/цэцэрлэгийн танхимын үйл ажиллагаа хаахаас өмнө цэцэрлэгт явж, сургуульд сурч байсан, хичээлийн жилийн төгсгөлд оноо авсан 6-17 насны хүүхдийн эзлэх хувь






СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН

Зайнаас сургах боловсролын талаарх сэтгэл ханамжийн түвшин

КОВИД-19 цар тахлаас өмнө цэцэрлэгт явж, сургуульд сурч байсан дор хаяж нэг хүүхэдтэй хариулагчийн хувь, зайнаас сургах боловсролын талаарх сэтгэл ханамжийн түвшинээр




() 25-49 жинлээгүй ажиглалтад суурилсан тооцоолол

Зайн сургалтад сэтгэл хангалуун байгаа эсэхийг тодруулахад 24 хувь нь зайн сургалтад зарим талаар эсвэл огт сэтгэл ханамжгүй байгаа бол судалгаанд оролцогчдын 9 орчим хувь нь хүүхдүүдийнхээ бие даан суралцаж буй байдалд сэтгэл хангалуун бус байна.

Хүүхдийн бие даан суралцаж буй байдлын талаарх сэтгэл ханамжийн түвшин

КОВИД-19 цар тахлаас өмнө цэцэрлэгт явж, сургуульд сурч байсан 6-17 насны хүүхдийн хувь, хүүхдийн бие даан суралцаж буй байдлын талаарх хариулагчийн сэтгэл ханамжийн түвшинээр



() 25-49 жинлээгүй ажиглалтад суурилсан тооцоолол

Үндэсний Статистикийн Хороо



Хаяг: Засгийн газрын III байр, Бага тойруу-44
Улаанбаатар – 11, Монгол улс



Утас: (+976) 11-326414

Лавлах утас: 1900-1212



Факс: (+976) 11-324518



Цахим хуудас: www.nso.mn



Цахим шуудан: information@nso.mn

Биднийг дагаарай!



Facebook | @StatisticMongolia



Twitter | @Statistic_nso

НҮБ-ын Хүүхдийн Сангийн Монгол дахь оффис



Хаяг: Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн Сан
НҮБ-ын Нэгдсэн байр, Нэгдсэн Үндэстний гудамж-14
Улаанбаатар 14201, Монгол улс



Утас: (+976) 11-312217
(+976) 11-312185



Цахим хуудас: www.unicef.org/mongolia



Цахим шуудан: ulaanbaatar@unicef.org

Биднийг дагаарай!



Facebook | @unicefmongolia



Twitter | @UNICEF_Mongolia